



## ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 22 өдөр

Дугаар А/346

Эрдэнэт


### Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5(а), 29.2 дахь заалт, Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2/2/, Соёлын өвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.7 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит 4 дүгээр хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Жаргалант сумын Айрагийн гозгорт буй 2 булшинд археологийн малтлага, судалгаа, топографийн зураглал, палеонтологийн судалгаа, сэргээн засварлалтын ажлыг хийж гүйцэтгэх зардалд 38000000 /Гучин найман сая/ төгрөгийг гаргасугай.

2.Шаардагдах 38000000 /Гучин найман сая/ төгрөгийг хөрөнгө оруулалтын жагсаалтын “Айрагийн гозгорын археологийн малтлагыг үргэлжлүүлэх, археологийн малтлагыг сэргээн засварлах арга хэмжээний зардлаас хуваарийн дагуу гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

3.Үйл ажиллагааны явц, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /н.Бумансор/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Д. БАТЛУТ